



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 11/89

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 27 дугаар зүйлийн 27.5.17 дах хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чандган багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг Чандган Коул ХХК нь 2313001142 нэгж талбарын дугаартай, уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалттай, газар ашиглах эрхийн гэрчилгээтэй газрын ашиглах эрхийн гэрээг дүгнэх ажлын хэсгийн байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хишигбаатар Хууль эрх зүйн мэргэжилтэн

Гишүүд: Д.Нямцэцэг Газрын даамал

Ж.Болорцэцэг Газар, геодези зураг зүйн хяналтын
улсын байцаагч (зөвшилцсөнөөр)

2. Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох тогтоомжийг баримтлан ажиллахыг ажлын хэсгийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР